

БАТЛАВ  
 МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
 Я.СОДБААТАР  
 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

2021 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ, ӨДӨРЛӨГИЙН ХУВААРЬ

А/А	Нэгдсэн арга хэмжээний нэр		2021 он											
			1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	"Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагааг, ам эхгүйн нэгж, байгууллага айл өрхийн тал түймрийн аюулгүй байдлыг хангуулах" нэгдсэн арга хэмжээ	Хамтран ажиллах байгууллага	■	■	■	■	■							
2	Өвөлжилт, хаваржилт хундрах болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ		■	■	■	■	■					■	■	■
3	Шар усны үеэрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ				■	■	■							
4	Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ							■	■	■	■			
5	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таныулах өдөрлөг				■									
6	Гэмшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг												■	
7	Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг				■									

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА



**ШАР УСНЫ ҮЕРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

Цаг агаарын дулааралттай холбоотойгоор цас ихтэй нутгууд, уулархаг газар, гуу, жалга, гол, мөрөн, нуурын цас, мөс эрчимтэй хайлах, мөсний нягт багасах үед иргэд явганаар болон тээврийн хэрэгслээр зорчин осолдох, хуурай сайраар шар усны үер буух аюулаас урьдчилан сэргийлэх, амжиж анхааруулахад оршино.

**Хоёр. Ерөнхий зүйл**

2.1. Гамшгаас хамгаалах тухай, Засгийн 2015 оны 286 дугаар тогтоол, Улсын их хурлын 2011 оны 22 дугаар тогтоол, Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл нь эрх зүйн үндэс болно.

2.2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад дээрх хууль тогтоомж, энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Энэхүү нэгдсэн арга хэмжээний хүрээнд шар усны аюулын эрсдэлтэй дэд бүтцийг хамгаалах, эрсдэл бүхий айл өрхүүдэд урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

2.4. Ард иргэдэд хүргэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгаа явуулах, гарын авлага, видео шторкыг албаны [www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn) цахим хуудаснаас татаж авна.

**Гурав. Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах  
бүрэлдэхүүн**

3.1. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гамшгаас урьдчилан сэргийлэх тасаг, нэгж

3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба

3.3. Ус цаг уур, орчны шинжилгээний газар

3.4. Хот тохижилтийн газар ОНӨААТҮГ

3.5. АЗЗА ХК

**Дөрөв. Хугацаа, хамрах хүрээ**

4.1. Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулна.

4.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны ард иргэд, тэдний гэр, орон сууц, зам, гүүр, үерийн далан, сувгийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдэнэ.

**Тав. Зохион байгуулагдах үйл ажиллагаа**

5.1. Мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг даргын захирамжаар томилох.

5.2. Цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан тодруулж, шар усны үер, мөс цөмрөхөөс урьдчилан сэргийлэх мэдээг иргэд, малчид, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай хүргэх, "Багц мессеж"-ээр давтамжтайгаар дамжуулах.

5.3. Гол, мөрөн, нуурын арал, тохой, эрэг дагууд болон уулын ам, бэл, гуу, жалга сувгийн ойролцоо айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бууж суурьшихгүй байхыг анхааруулах, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхийн судалгааг гаргаж, мэдэгдэл хүргүүлэн, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх.

5.4. Үерийн хамгаалалтын далан, зам, гүүрийн ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламжид үзлэг, шалгалт зохион байгуулж, далан, суваг, шуудууны цэвэрлэгээг хариуцагч байгууллагаар хийлгэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах.

5.5. Төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тээврийн хэрэгслийн жолооч, малчид, иргэдэд гол, мөрөн, нуурын мөсөн дээгүүр зорчихгүй байх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээ тогтмол хүргэх, баталгаагүй гарц, гарам дээр самбар байршуулж сэрэмжлүүлэх.

5.6. Болзошгүй аюулт үзэгдэл, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран шуурхай ажиллахыг үүрэг болгож байна.

5.9. Нэгдсэн арга хэмжээний хугацаанд сум, баг, хороо, дүүрэг дээр 2-оос доошгүй удаа өдөрлөг зохион байгуулах.

5.10. Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг болон нэгдсэн арга хэмжээг төв, орон нутгийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэх.

5.11. Зохион байгуулсан арга хэмжээний дүн, мэдээг 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтний [ariunaanema@gmail.com](mailto:ariunaanema@gmail.com) цахим хаягаар гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудсын хамт ирүүлнэ.

#### **Зургаа. Нэгдсэн арга хэмжээний үр дүн, шаардагдах зардал**

6.1. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2. Улсын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн талаар дүнг Гамшгаас урьдчилан сэргийлэх газар нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын даргад 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулна.

6.3. Нэгдсэн арга хэмжээг явуулахад шаардлагатай зардлыг тухайн шатны Засаг даргын тамгын газрын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал, Онцгой байдлын газар, хэлтэс, Олон улсын хүмүүнлэгийн байгууллага, Төрийн бус байгууллагын гамшгаас урьдчилан сэргийлэх зардлаас тус тус санхүүжүүлнэ.

### **ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**